



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/158/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

Шүүхийн шинжилгээний албаны
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Аудитын менежер: А.Цэням

Утас: 99442140

Аудитор:

Утас: 88117644

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Б.Цэрэнчимэд.

Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.8.2	Төлбөрийн акт тогтоох хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail, bayankhongor@audit.gov.mn

2020.01.30 № 1/28

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

2519394

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Б.МӨНХБАТ

A4-2020

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шүүхийн шинжилгээний албаны дарга Д.Мөнхбаатарт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.20-ноос 2020.01.29-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.01.30-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.20-ны өдрийн 13в/21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шүүхийн шинжилгээний албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь "Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч, нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Тус байгууллагын Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acoulus" программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 31 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 25 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2,0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд нийт зардлын дүнг сонгосон тул гүйцэтгэлийн шатанд суурь үзүүлэлтийг өөрчлөөгүй болно.

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны Үр дүнгийн тайлангийн нийт зардал

154407,5 мянган төгрөг бөгөөд түүний 2,0 хувь болох 3088,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 31 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 28 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(Сая төгрөгөөр)
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.05	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	1.05	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитаар "аймгийн ТЕЗ-ийн харьяанд хамаарагддаггүй байгууллагад

бэлтгэж өгсөн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгүүлэн, хөрөнгө ашиглалтын гэрээ байгуулж, ажиллах" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Шүүхийн шинжилгээний албанд орон нутгийн хөрөнгөөр худалдан авсан автомашиныг тухайн байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байгаа тул аудитын явцад санхүүгийн тайланд 30.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасуулж залруулга хийв.

2.8.2 Төлбөрийн акт тогтоох хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Авлага, өглөгийн тооцоог анхан шатны баримт болон журналын бичилтээр тулган шалгахад Цагдаагийн газарт байр ашиглалтын зардал шилжүүлэхдээ 50,0 мянган төгрөгийг НДШ-ийн зардлын кодоор буруу бичиж илүү шилжүүлж, зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8"төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Аймгийн ИТХ-ын Шүүхийн шинжилгээний албаны 2019.10.17-ны 1а/466 тоот албан бичгээр аймгийн ОНӨГ-ын даргад "Цагдаагийн газрын хуучин барилгын тодорхой хэсгийг ашиглаж буй ШША-ны ашиглалтын гэрээг тухай онд байр ашиглалттай холбоотой батлагдсан төсөвт багтааж, хэрэгжүүлэх гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна..

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татхуйц асуудал байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ШШАлба нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын төсвөөс 136332,5 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоор 6000,0 мянган төгрөгийн орлого оруулах, нийт 142332,5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 140836,6 мянган төгрөг байна. Тайлант хугацаанд батлагдсан төсвийг хэтрүүлээгүй бөгөөд цалингийн зардал 20,8 мянган төгрөг, НДШ-ийн зардал 1430,0 мянган төгрөг, БГБҮБЗардал 45,0 мянган төгрөг буюу нийт 1495,8 мянган төгрөгөөр хэмнэгдэж, буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 1604,5 мянган төгрөгийн орлого орж, зарцуулагдсан байна. Энэ нь Сангийн сайдын Шүүхийн шинжилгээний албаны 2019.11.22-ны 251 тоот тушаалаар хоол-496.6 мянга, багаж техник хэрэгсэл-803.6 мянга, урсгал засварт 304.3 мянган төгрөг буюу нийт 1604,5 мянган төгрөгийн зарцуулах зөвшөөрөл олгожээ.

Тухайн байгууллага нь Шүүхийн шинжилгээний албаны 2019 онд төвлөрүүлэх орлогын төлөвлгөө байхгүй

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	34	2	
	Тухай бүр	8	96	93	3	
	Нийт	27	151	144	5	2

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны аудитаар өгсөн нэг зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд зөвлөмжийн хариуг ШШАлбаны даргын Шүүхийн шинжилгээний албаны 2019.04.15-ны өдрийн 13в/127 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Аудитаар Шүүхийн шинжилгээний албаны 2019.01-05-р сард цалингаас суутгасан дундын фондны 400,0 мянган төгрөг, 9-р сард П.Хонгорзул, Б.Баяртогтох нарт олгосон урьдчилгаа 1000,0 мянган төгрөгийн дансны бичилтийг цалингийн өглөгийн дансаар буруу бичилт хийсэн байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан журмын 3.6-ийн б-д "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ"

Дт. Бусад өглөг - ажиллагчийн төлөх бусад суутган төлбөр,

Кт. Мөнгөн хөрөнгө/,

3.6-ийн д-д "Цалинг урьдчилж төлөхөд"

Дт. Урьдчилгаа- цалин,

Кт. Мөнгөн хөрөнгө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Цалин, НДШ, ХХОАТ-ын тооцооллыг буруу хийсэн байх

3.1.3 Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан зааврын 3.6-ын б"Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ" гэсэн заалтыг мөрдөж, цалингаас суутгасан дундын фондны болон урьдчилгаа олгосон дансны бичилтийг зөв хийж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020.03.31-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,510,419.00	1,218,919.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,510,419.00	1,218,919.00
351	Түүхий эд материал	161,000.00	00.00
35110	Тусгай зориулалттай материал	161,000.00	00.00
354	Хангамжийн материал	1,349,419.00	1,218,919.00
35410	Бичиг хэргийн материал	80,000.00	115,000.00
35420	Аж ахуйн материал	27,200.00	53,200.00
35440	Түлш, шатах тослох материал	1,081,219.00	938,219.00
35470	Бусад хангамжийн материал	161,000.00	112,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,880,716.29	13,770,399.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,880,716.29	13,770,399.47
392	Биет хөрөнгө	20,880,716.29	13,770,399.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,999,999.88	-16,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,147,329.00	31,409,713.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,523,966.53	-19,847,593.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,544,400.00	4,876,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,287,046.30	-2,668,119.68
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	22,391,135.29	14,989,318.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	22,391,135.29	14,989,318.47
51	Засгийн газрын хувь оролцоо	22,391,135.29	14,989,318.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,515,100.00	9,515,100.00
51101	Өмч: - төрийн	9,515,100.00	9,515,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	12,876,035.29	5,474,218.47
51210	Өмнөх үеийн үр дүн	12,876,035.29	12,876,035.29
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-7,401,816.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	22,391,135.29	14,989,318.47

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	134,877,000.00	144,439,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,665,800.00	6,502,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,665,800.00	6,502,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,665,800.00	6,502,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,435,000.00	6,502,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,230,800.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,211,200.00	137,937,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	124,211,200.00	136,332,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,604,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,604,500.00
131105	төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд оги болсон нэмэлт орлого	00.00	1,604,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	141,417,238.62	151,840,816.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	141,417,238.62	151,840,816.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138,006,944.62	149,842,335.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	99,591,123.50	110,463,533.00
210101	Үндсэн цалин	58,919,635.50	64,461,600.00
210102	Нэмэгдэл	30,266,004.00	34,574,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,405,484.00	11,427,133.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,238,960.50	2,209,271.00
210201	Тэтгэврийн даатгал	1,078,287.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,160,673.50	2,209,271.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,800,000.00	6,876,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,092,800.00	1,550,000.00
210302	Түлш, халаалт	3,107,200.00	3,845,400.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	1,480,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,900,178.00	12,912,100.00
210401	Бичиг хэрэг	1,706,800.00	1,736,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,271,981.00	8,893,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,380,441.00	1,140,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	95,810.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,445,146.00	1,043,100.00
2105	Нормативт зардал	5,419,475.00	5,126,725.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,268,600.00	4,630,100.00
210502	Хоол, хүнс	1,150,875.00	496,625.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	00.00
2107	Томилт, зочны зардал	2,998,500.00	2,693,000.00
210702	Дотоод албан томилт	2,998,500.00	2,693,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,356,990.00	1,696,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,196,990.00	1,312,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,000.00	228,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	00.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,701,717.62	7,865,306.82
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,701,717.62	7,865,306.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,410,294.00	1,998,481.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,410,294.00	1,998,481.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,410,294.00	1,998,481.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,540,238.62	-7,401,816.82
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,105.53	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,105.53	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-4,105.53	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-6,544,344.15	-7,401,816.82

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	132,646,200.00	144,439,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,435,000.00	6,502,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,435,000.00	6,502,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,435,000.00	6,502,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,435,000.00	6,502,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,211,200.00	137,937,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	124,211,200.00	136,332,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	124,211,200.00	136,332,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,604,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,604,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	132,646,200.00	143,684,010.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	132,646,200.00	143,684,010.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,235,906.00	141,685,529.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	99,585,852.00	110,463,533.00
210101	Үндсэн цалин	58,310,700.00	64,461,600.00
210102	Нэмэгдэл	30,869,668.00	34,574,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,405,484.00	11,427,133.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,244,232.00	2,259,271.00
210201	Тэтгэврийн даатгал	1,084,810.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	50,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,159,422.00	2,209,271.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,800,000.00	6,826,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,200,000.00	1,550,000.00
210302	Түлш, халаалт	3,000,000.00	3,845,400.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	1,430,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,497,622.50	12,620,000.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,610,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,500,000.00	8,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,301,816.50	1,140,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	95,810.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,996.00	1,020,000.00
2105	Нормативт зардал	4,150,875.00	4,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,000,000.00	4,000,000.00
210502	Хоол, хүнс	1,150,875.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,000.00	640,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,000.00	640,700.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,998,500.00	2,693,000.00
210702	Дотоод албан томилолт	2,998,500.00	2,693,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,358,824.50	2,182,725.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,198,824.50	1,648,925.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	228,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	00.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,410,294.00	1,998,481.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,410,294.00	1,998,481.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,410,294.00	1,998,481.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	754,990.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	754,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	754,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	754,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	754,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-754,990.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,515,100.00	9,703,768.05	19,218,868.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,515,100.00	9,703,768.05	19,218,868.05
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	21,953,145.79	21,953,145.79
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,515,100.00	12,876,035.29	22,391,135.29
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,515,100.00	12,876,035.29	22,391,135.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,515,100.00	12,876,035.29	22,391,135.29
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	-7,401,816.82	-7,401,816.82
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,515,100.00	5,474,218.47	14,989,318.47

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	131,711,200.00	129,235,906.00	142,332,500.00	140,836,604.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,711,200.00	129,235,906.00	142,332,500.00	140,836,604.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,711,200.00	129,235,906.00	142,332,500.00	140,836,604.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	99,591,400.00	99,585,852.00	110,484,400.00	110,463,533.00
210101	Үндсэн цалин	58,310,700.00	58,310,700.00	64,461,600.00	64,461,600.00
210102	Нэмэгдэл	30,869,700.00	30,869,668.00	34,574,800.00	34,574,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,411,000.00	10,405,484.00	11,448,000.00	11,427,133.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,689,300.00	2,244,232.00	3,689,300.00	2,259,271.00
210201	Тэтгэврийн даатгал	2,069,300.00	1,084,810.00	1,218,800.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	188,000.00	00.00	188,000.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	235,000.00	00.00	234,800.00	50,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	47,000.00	00.00	47,200.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,150,000.00	1,159,422.00	2,000,500.00	2,209,271.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,800,000.00	4,800,000.00	6,826,300.00	6,826,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,200,000.00	1,200,000.00	1,550,000.00	1,550,000.00
210302	Түлш, халаалт	3,000,000.00	3,000,000.00	3,416,900.00	3,845,400.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00	1,859,400.00	1,430,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,500,000.00	12,497,622.50	12,620,000.00	12,620,000.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,600,000.00	1,610,000.00	1,610,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,500,000.00	8,500,000.00	8,750,000.00	8,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,302,000.00	1,301,816.50	1,140,000.00	1,140,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	98,000.00	95,810.00	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	999,996.00	1,020,000.00	1,020,000.00
2105	Нормативт зардал	4,152,000.00	4,150,875.00	4,000,000.00	4,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	4,000,000.00	4,000,000.00
210502	Хоол, хүнс	1,152,000.00	1,150,875.00	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,000.00	1,600,000.00	640,700.00	640,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,000.00	600,000.00	640,700.00	640,700.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	00.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,998,500.00	2,693,000.00	2,693,000.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,998,500.00	2,693,000.00	2,693,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,378,500.00	1,358,824.50	1,378,800.00	1,333,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,200,000.00	1,198,824.50	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	150,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,500.00	30,000.00	228,800.00	228,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	100,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00	100,000.00	100,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	131,711,200.00	129,235,906.00	142,332,500.00	140,836,604.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	124,211,200.00	121,735,906.00	136,332,500.00	134,334,604.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	124,211,200.00	121,735,906.00	136,332,500.00	134,334,604.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,500,000.00	7,500,000.00	6,000,000.00	6,502,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,500,000.00	7,500,000.00	6,000,000.00	6,502,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		09		09
620001	Удирдах ажилтан		01		01
620002	Гүйцэтгэх ажилтан		08		08
650002	Тсрийн тусгай албан хаагч (ТТ)		09		09

Тайланг бэлтгэсэн: Аудитор

Б.Цэрэнчимэд

Анхан шатны хяналт хийсэн: Аудитын менежер

А.Цээням

Хоёр дахь шатны хяналт хийсэн: Тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

